

Баруун бүсийн “Хариуцлагатай Уул Уурхай” өдөрлөгийн зөвлөмж



Говь-Алтай аймаг, Алтай хот 2023.09.14-15

1. Хуулийн хүрээнд Засгийн газар, аж ахуйн нэгж болон иргэд тэгш шударгаар хамтран ажиллах;
2. Төрийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаа сайтар ухамсарлах;
3. Иргэдэд цаг үеийн байдалтай мэдээ, мэдээллийг тогтмол олон нийтийн хэрэгслээр явуулж хэвших;
4. Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах болон зөв эерэг өв уламжлал бий болгох;

Нийтлэг



1. Мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхээс сэргийлж, мэдээ, мэдээллийг тогтмол олон нийтийн хэрэгслээр явуулж хэвших;
2. Орон нутгийн иргэдийн эсэргүүцэлд зөв мэдээлэл өгөхийн тулд тухайн аймгийн засаг даргын тамгын газартай тодорхой бодлогоор хамтран ажиллах;
3. Иргэний нийгэм, олон нийт, экспертүүд, мэргэжлийнхний дэвшүүлж буй үндэслэлтэй асуудлуудад шийдэл олох (хуулийн хийдэл, цоорхой, хууль хэрэгждэггүй байдал гэх мэт);
4. Салбар хоорондын уялдааг сайжруулах;
5. Орон нутгийн удирдлагуудыг чадавхжуулах;
6. Говь-Алтай аймагт орон нутгийн удирдлагад нүүрсний тусгай зөвшөөрөл олгох, орон нутгийн өмчийн компани үүсгэх зөвшөөрлийг олгох;
7. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн одоогийн мөрдөж буй хугацааг багасгах;

Уул уурхай,
хүнд үйлдвэрлэлийн
яаманд:



1. Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах болон зөв эерэг өв уламжлал бий болгох;
2. Иргэний нийгэм, олон нийт, экспертүүд, мэргэжлийнхний дэвшүүлж буй үндэслэлтэй асуудлуудад шийдэл олох (хуулийн хийдэл, цоорхой, хууль хэрэгждэггүй байдал гэх мэт);
3. Салбар хоорондын уялдааг сайжруулах;
4. Орон нутгийн удирдлагуудыг чадавхжуулах;

Байгаль орчин аялал жуулчлалын яаманд:



1. Уул уурхайн салбартай холбоотой боловсруулж буй хуулийн ажлын хэсэгт орон нутгийн төлөөллийг заавал оруулдаг байх журмыг бий болгох;
2. Орон нутгийн удирдлагуудыг чадавхжуулах;
3. Оролцоог хангахад чиглэсэн хууль, журмын хэрэгжилтийг хангах (сонсох ажиллагаа, хөндлөнгийн хараат бус хяналт, талуудын тэгш оролцоо гэх мэт);
4. Ашигт малтмалын тухай хуулийн 12-р зүйлд аймгийн Засаг дарга үндэслэлтэй тохиолдолд дэмжихгүй санал өгөх эрхтэй болгох;

Хууль зүй, дотоод хэргийн яаманд:



1. Ашигт малтмалын тухай хуулийн 17.5.2-д заасан шаардлагын дагуу тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар, нөөцөд авсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй байх талбайг сонгож хайгуулын тусгай зөвшөөрөл олгох;

Ашигт малтмал газрын тосны газарт:



1. Ил тод нээлттэй байдлыг бодитоор хэрэгжүүлэх, зөвлөмж, шүүмжлэл, саналуудад ач холбогдол өгч хэвших;
2. Цахим сайтаа иргэд хэрэглэхэд илүү хялбар, ойлгомжтой болгох;
3. ОУИТБ-ын санаачлагын тайлан гаргахад Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн албан татвар, төлбөр, хураамж талаар мэдээллийг татварын албанаас гаргуулах талаар холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах;
4. ОУИТБ-ын дэд зөвлөлийн удирдлагыг иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх;

Олборлох
үйлдвэрлэлийн ил тод
байдлын санаачилгын
ажлын албанд:



1. Уул уурхайн компаниудын үйл ажиллагааг нэгтгэсэн байдлаар олон нийтэд мэдээлэлдэг байх;



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

1. Аймаг бүр уул уурхайн тодорхой бодлоготой болох;
2. Уурхай дээр ашиглаж буй тоног төхөөрөмжийн бүртгэлийг сайжруулах;
3. Уурхай дээр ашиглаж буй тоног төхөөрөмжийг орон нутагт бүртгэлжүүлдэг болох;
4. Орон нутгийн албан хаагчдыг чадавхжуулах;
5. Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах;
6. Мэргэжилтнүүдийн холбогдох сургалт, семинарт саадгүй оролцуулах;
7. Аймаг болон сум хоорондын уялдааг сайжруулах;
8. Орон нутгийн гэрээг аймаг, сум, компани гээд гурвалсан байдлаар байгуулдаг болох;

Аймгуудын Засаг даргын тамгын газарт:



1. Иргэний нийгмийн байгууллагуудын гишүүдийг чадавхжуулах;
2. Иргэдэд цаг алдалгүй мэдээ, мэдээллүүдийг хүргэж байх;
3. Орон нутгийн засаг даргын тамгын газар болон аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, тогтмол сургалт, уулзалт зохион байгуулж ойлголцлыг хангадаг байх;

Иргэний нийгмийн байгууллагад:



1. Байгаль орчны нөхөн сэргээлтийг хийхдээ аль болох өмнө нь байсан унаган төрх рүү ойртуулах;
2. Мэргэжил, сургалтын төвд орон нутгаас залуучуудыг сурах тодорхой нөхцөл боломжоор хангах;
3. Оюутнуудыг дадлагажуулж, тухайн уурхайн ажиллах нөхцөл орчинтой танилцах боломжоор хангах;
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар аймгийн төв дээр төлөөлөгчийн газартай болох;
5. Ажилчдаа орон нутагт амьдрах нөхцөл бололцоогоор хангах;
6. Нөлөөнд өртсөн орон нутгийн иргэдийн хүсэл сонирхол болон хүний эрхийг хүндэтгэх, аюулгүй, эрүүл мэндэд хоргүй ажлын орчинг бий болгох,
7. Иргэдийн дунд мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхээс сэргийлж тогтмол мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны тайланг олон нийтийн хэрэгслээр түгээдэг байх;
8. Нөлөөллийн бүсэд амьдарч буй орон нутгийн иргэдийн хүсэл сонирхол болон хүний эрхийг хүндэтгэх, аюулгүй байдлыг хангах;

Компаниудад:



9. Үйл ажиллагаа явуулж орон нутгийн иргэдийн амдралын чанарт нөлөөлж буй судалгааг улирлаар гаргадаг байх;

10. Орон нутгийн засаг даргын тамгын газар болон иргэдтэй тогтмол сургалт, үйл ажиллагаа явуулж хэвших,

11. Нийгмийн хариуцлагын гэрээний биелэлт болон улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар мэдээллийг иргэдэд танилцуулдаг байх;

12. Тухайн төслийн ТЭЗҮ, байгаль орчн ыүнэлгээг чанартай сайн хийж, уурхайн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах, уурхайн хаалт зэргийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, уурхайг ашиглаж дууссаны дараа хөдөө аж ахуйн салбарт ашиглахад бэлэн болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд хариуцлагатай байж, нутгийн иргэдийн хоорондын үл ойлголцлыг арилгах;

Компаниудад:





БАНУУН БҮСИЙН
“ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ”
өдөрлөгийн оролцогчид:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Ашигт малтмал, газрын тосны газар
- Экологийн цагдаагийн алба
- Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
- ОУИТБС-ийн ажлын алба
- Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл
- Төлсөн авснаа нийтэл-"ТАН" эвсэл
- Монголын Байгаль орчны иргэний зөвлөл
- Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл

- Орон нутгийн иргэд
- Говь-Алтай, Завхан, Увс, Баян-Өлгий, Ховд аймгуудын ЗДТГ-ийн удирдлага, албан хаагчид
- ОУИТБС-ын дэд зөвлөлийн гишүүд
- Австрали-Монголын АМЕП-2 хөтөлбөр
- Хан-Алтай ресурс ХХК
- МоЭнКо ХХК
- Иннова Минерал ХХК
- Макс групп
- Халзан бүргэдээ төсөл
- Мера групп зэрэг аж ахуйн нэгжийн төлөөлөл, удирдлага, хамт олон, гишүүд, ажилтнууд гээд нийт 300 орчим зочид, төлөөлөгчид оролцлоо.